

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ  
(2022 он)

2023.02.01

Дархан-Уул

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот	Хүрсэн	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас алба хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	15	19	1.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид нийт 19 удаагийн сургалтад хамрагдсан. Үүнд: ✓ Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7x4x10, ✓ Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институтийн Орон нутгийн хөгжлийн стратеги, бодлогын төлөвлөлт, Төсвийн хөрөнгө оруулалт, ✓ Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, ✓ Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг ✓ БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтын хамтарсан нутгийн захиргааны албан хаагчдыг чадавхжуулах сургалт, ✓ E-Mongolia академи Төрийн албан хаагчдын мэдээллийн технологи ашиглах ур чадварыг дээшлүүлэх сургалт, ✓ Удирдлагын академи, Мэргэшил дээшлүүлэх институт Мерит төсөлтэй хамтран зохион байгуулсан “Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ+” цахим сургалт, ✓ Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалт, ✓ ТАЗ, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, ЛЭОС-аас хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр”-ийн 3 сарын сургалт / 2 албан хаагч/, ✓ Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс танхимаар зохион байгуулсан “Эрх зүйн хөтөч”-ийн 16 цагийн сургалт / 1 албан хаагч/, ✓ МУ-ын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос “Удирдах ажилтанд зориулсан Ж1” сертификаттай цахим 8 цагийн сургалт / 1 албан хаагч/,
			Ажлын байран дахь сургалт	4	5	
		Үүнээс	Мэргэшүүлэх сургалт	5	8	
			Туршлага солилцох арга хэмжээ	1	1	
			Бусад	5	5	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	44	105	
			Эмэгтэй албан хаагч	27	80	
			Эрэгтэй албан хаагч	17	25	
		Үүнээс	Удирдах албан тушаалтан	12	20	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	32	85	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100%			

2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	1-ээс доошгүй	1	<ul style="list-style-type: none"> <li>✓ Удирдлагын академиас цахимаар зохион байгуулсан “Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах нь” сэдэвт 20 цагийн сургалт / 1 албан хаагч/,</li> <li>✓ НҮБ-ийн дэмжлэгээр Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын ёс зүй, цогц чадамжийн үндэсний жишиг хөтөлбөр боловсруулах” танхимын 8 цагийн сургалт /5 албан хаагч/,</li> <li>✓ Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллага, Авлигатай тэмцэх газраас хамтран зохион байгуулсан "Авлига ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" онлайн сургалт / 1 албан хаагч/</li> <li>✓ “Төрийн албаны шинэтгэл” арга хэмжээний хүрээнд ТАЗСЗ-өөс зохион байгуулсан “Харилцааны тухай бид юуг ойлгох ёстой вэ?”, “Харилцаан дахь бидний ялгаа” сэдэвт сургалт /25 албан хаагч/,</li> <li>✓ Жижиг бизнес эрхлэгч, сургагч багш нарыг бэлтгэх</li> </ul>
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	1	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	1	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	1	

		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	43.47%	<p>дунд хугацааны сургалт /1албан хаагч/ нийт 19 удаагийн сургалтад давхардсан тоогоор 105 албан хаагч хамрагдсан.</p> <p>Албан хаагчдыг мэргэшүүлэн чадавхижуулах зорилгоор Удирдлагын академи Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 9, шинээр томилогдсон албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтад 1, албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 4, ахлах түшмэлийн багц сургалтад 1, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 1, нийт 16 албан хаагч зайн хэлбэрээр суралцаж үнэмлэх авсан.</p> <p>1.2 105 албан хаагч (давхардсан тоогоор) 19 удаагийн сургалтад хамрагдсан. Үүнээс эмэгтэй 80, эрэгтэй 25, удирдах 20, гүйцэтгэх 85 албан хаагчид тус тус хамрагдсан.</p> <p>1.3. Батлагдсан 46 орон тооны бүх албан хаагчид буюу 100% хамрагдсан.</p> <p>2.1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Нутгийн удирдлагын хөгжлийн институтын хамтарсан “НУТГИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ” солонгос хэл дээр (орчуулгатай) цахим сургалтанд аймгийн ЗДТГ-ын 19 албан хаагч, Энэтхэг улсын техник эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд БНЭУ-ын элчин Сайдын тэтгэлгээр “Жижиг бизнес эрхлэгч, сургагч багш нарыг бэлтгэх дунд хугацааны сургалт”-д Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн 2 сарын хугацаатай суралцаж төгссөн.</p> <p><b>Сайн тал:</b> Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүлийн Шинжлэх ухааны их сургуулийн профессор, хүндэт профессор багш нарын заасан “Нутгийн захиргааны албан хаагчдыг чадавхижуулах” солонгос хэл дээр (орчуулгатай) цахим сургалтад 19, БНЭУ-д англи хэлээр зохион байгуулагдсан сургалтад 1, нийт 20 албан хаагч буюу 43.47% нь хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.</p>
--	--	------	--	-------------	--------	--

3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Гүйцэтгэл	4.5 (сая.төг)	<p>“Төрийн албаны шинэтгэл” арга хэмжээний хүрээнд ТАЗСЗ-ийн даргын баталсан “Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдыг мэргэшүүлэх арга зүйн сургалт”-ын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан “Харилцааны тухай бид юуг ойлгох ёстой вэ?”, “Харилцаан дахь бидний ялгаа” сэдэвт сургалтанд аймгийн ЗДТГ-ын 25 албан хаагч хамрагдлаа. Сургалтыг 3.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/40 дүгээр захирамжийн хэрэгжилт, Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2021 он, 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий танилцуулга, анхаарах буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд, эдгээрийг шийдэх гарц шийдэл, боломжийн талаар санал солилцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө чиглэл өгөх зорилгоор ХШҮХ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн ЗДТГ-ын 24 (давхардсан тоогоор) албан хаагчдад зөвлөн туслах үйлчилгээ, сургалтыг бодлогын 8 баримт бичгийн хүрээнд зохион байгууллаа. Сургалтын зардалд 0.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Аймгийн ЗДТГ-ын НБХ-ээс “Жендерийн бодлого, төлөвлөлт хийх нь” сургалтыг жендерийн бодлого хариуцсан мэргэжилтэн зохион байгуулахад 1.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайлант онд нийт 5.0 төгрөг төсөвлөснөөс 4.5 сая төгрөгийг зарцууллаа.</p>
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	15.2%	<p>3.2.Төрийн албаны тухай хуулийн 46.2.4 дэхь заалтаар 7 чөлөөлсөн байна.</p> <p>Чөлөөлөгдсөн /албан хаагчдын дундаж*100= 7/46*100=15.2%</p>
<b>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах</b>						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	17.6%	<p>2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээр албан хаагчдын цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардал. Үүнд:</p> <p>-Албан хаагчдын үндсэн цалин- 503,241,311.10 төгрөг</p> <p>-Урамшуулал- 52,763,885.00 төгрөг</p> <p>Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал – 22,369,449.00 нийт 578,374,645,10 төгрөгийг тус тус олгосон.</p>

		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	5000	6000	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022.02.09-ны өдрийн Дугаар 02-А/24 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 1 албан хаагчдад хоолны нэмэгдэл 4000 төгрөг, унааны нэмэгдэл 2000 нийт 6000 төгрөгийг тус тус олгож, өмнөх оны мөн үеэс 1000 төгрөгөөр нэмэгдүүлсэн.
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	85.0%	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 39 албан хаагчдаас “Албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн болон ажлын сэтгэл ханамж” сэдвийн хүрээнд санал асуулгыг авахад: нийт албан хаагчдын 85.0% байгууллагынхаа дотоод уур амьсгалд сэтгэл ханамжтай, 65.0% нь ажлын байранд сурч хөгжих, боломж дунд зэрэг, 54.9% нь хамт олноосоо ажиллах хүсэл эрмэлзлэл авдаг буюу мотивациждаг, 57.5% нь эрүүл ахуй, цэвэр орчныг бүрдүүлсэн гэж тус тус хариулсан байна. <b>Гарсан үр дүн:</b> аймгийн Засаг дарга, удирдлагуудад судалгааны дүгнэлтийг танилцуулсны үр дүнд: 1. Аймгийн ЗДТГ-ын байранд байрлаж байсан аймгийн Захирагчийн ажлын албыг нүүлгэн шилжүүлж өрөөг 58.506 сая төгрөгөөр засварлан Төрийн захиргааны удирдалгын хэлтсийг шилжүүлэн оруулж, 16.9 сая төгрөгөөр Санхүү, төрийн сан, Нийгмийн бодлогын хэлтсүүдийн өрөөүүдэд засваруудыг хийж тохижуулсан. Албан хаагчдыг сургалтад хамруулахаар 2023 оны төсөвт сургалтын зардал 20.0 сая төгрөгийг батлуулсан.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	2	Монгол Улсын хэмжээнд орон даяар ЭМЯ-с зохион байгуулж буй “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ”-д 32, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан төрөлжсөн шинжилгээнд 25 албан хаагчийг хамрууллаа. 2022 онд 2 удаагийн оношилгоо, төрөлжсөн шинжилгээнд 42 /давхардсан тоогоор 57/ албан хаагчийг хамрууллаа.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	91.3%	Аймгийн ЗДТГ-ын 46 албан хаагчдаас 42 албан хаагч буюу 91.3% нь хамрагдсан.

7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	643,3 (сая.төг)	<p>2022 оны жилийн эцсээр өссөн дүнгээр “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг үндэслэн албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цалин: 503,241,311.10 төгрөг</li> <li>- Унаа хоолны хөнгөлөлт: 52,561,850.50 төгрөг</li> <li>- Үр дүнгийн урамшуулалд: 52,763,885.00 төгрөг</li> <li>- Буцалтгүй тусламж: 22,369,449.00 төгрөг</li> <li>- Төрсөн нутагтаа амарсан: 0,00 төгрөг</li> <li>- Түлээ нүүрсний хөнгөлөлтөд 0,00 төгрөг</li> <li>- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4 зүйлийн дагуу илүү цагаар ажилласан 23 албан хаагчид 1,422,963 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.</li> </ul> <p>Зайлшгүй ажлын шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 1 албан хаагчид 1,552,806.00 мөнгөн урамшуулал олгосон.</p> <p>Цалинтай чөлөөг нийт 19 албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацааны дагуу олгож, чөлөөний олговорт 9,303,675.00 төгрөг тооцож олгосон.</p>
----	--	------	--	---	--------------------	--

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН

ЗДТГ-ЫН ДАРГА

О.ХҮРЭЛЧУЛУУН

ХЯНАСАН:

ТЗУХ-ИЙН ДАРГА

Д.ЧАГНААДОРЖ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЯМАА

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

2023.02.08

Дархан-Уул аймаг

№	Биелэлт	Бүгд	Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвжүүлэх			Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах				
			Нэг	Хоёр	Гурав	Дөрөв	Тав	Зургаа	Долоо	
1.	Үйл ажиллагааны тоо	14	3	3	2	2	1	2	1	
2.	Үнэлгээ, үүнээс	100.0%	12	3	3	1	2	1	2	-
		90.0%	2	-	-	1	-	-	-	1
		70.0%	-	-	-	-	-	-	-	-
		50%	-	-	-	-	-	-	-	-
		30%	-	-	-	-	-	-	-	-
<b>Ерөнхий үнэлгээ</b>		<b>98.57% буюу 4.92 оноо</b>	<b>100% буюу 5.0 оноо</b>	<b>100% буюу 5.0 оноо</b>	<b>95.0% буюу 4.75 оноо</b>	<b>100% буюу 5.0 оноо</b>	<b>100% буюу 5.0 оноо</b>	<b>100% буюу 5.0 оноо</b>	<b>90.0% буюу 4.5 оноо</b>	

ТАНИЛЦСАН:  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН  
ДАРГА О.ХҮРЭЛЧУЛУУН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН